



# ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Байгууллагын нэр: Монгол Улсын Их сургууль  
Шинжлэх ухааны сургуулийн  
Байгалийн шинжлэх ухааны салбар  
Геологи, геофизикийн тэнхим

Хөтөлбөрийн нэр: Геофизикийн бакалаврын хөтөлбөр

Индекс: D053205

Шинжээчийн баг:

Ахлагч: П.Дугараа  
Гишүүд: Т.Балжинням  
Т.Чулуунцэцэг

Улаанбаатар хот  
2021 он

# **Агуулга**

## **Товчилсон үгийн тайлбар**

### **I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**

### **II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**

### **III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

### **IV. Уулзалтад оролцогчдын нэрс**

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

### **V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**

#### **VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**

#### **VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

## Товчилсон үгийн тайлбар

- АНУ	Америкийн Нэгдсэн Улс
- БШУЯ	Боловсрол Шинжлэх Ухааны Яам
- БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
- БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
- ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
- МУ	Монгол Улс
- МУИС	Монгол Улсын Их Сургууль
- МГФХ	Монголын геофизикчдын холбоо
- МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
- НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
- ОХУ	Оросын Холбооны улс
- ООГХ	Одон орон геофизикийн хүрээлэн
- ТӨҮГ	Төрийн өмчийн үйлдвэрийн газар
- ТББ	Төрийн бус байгууллага
- ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
- УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
- ҮХЦБ	Үндэсний хөгжлийн цогц бодлого
- ШУС	Шинжлэх Ухааны Сургууль
- ШУТИС	Шинжлэх Ухаан Технологийн Их сургууль
- ШУА	Шинжлэх ухааны академи
- ШУ	Шинжлэх ухаан
- ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт

### Гадаад үгс

- Wos	Web of Science
- IF	Impact Factor
- SiSi	МУИС-ийн СиСи сургалтын мэдээллийн систем

## I.Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	<ul style="list-style-type: none"> <li>• Монгол Улсын Их сургууль, Шинжлэх ухааны сургууль</li> <li>• Science School of Mongolian National University</li> </ul>	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	<ul style="list-style-type: none"> <li>• “Геофизик” бакалаврын хөтөлбөр</li> <li>• Geophysicist</li> </ul>	
Индекс	<ul style="list-style-type: none"> <li>• D053205</li> </ul>	
	<ul style="list-style-type: none"> <li>• П.Дугараа - Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Геологи, уул уурхайн сургуулийн Геофизикийн сургалт, үйлдвэрлэл, судалгааны төвийн захирал</li> <li>• Т.Балжинням - Хөдөө аж ахуйн их сургуулийн Агроэкологийн сургуулийн Газрын менежментийн тэнхимийн зөвлөх профессор</li> <li>• Т.Чулуунцэцэг - Герман Монголын МСҮТ-ийн хүний нөөцийн менежер, орчуулагч</li> </ul>	
БМИУЗ-ийн зохицуулагч	<ul style="list-style-type: none"> <li>• П.Оргилмаа - Магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн</li> </ul>	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b> /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2021.09.24	Мэргэжлийн шинжээчдийг нэрсийг хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багт илгээж, ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар саналыг хүлээн авах
	2021.09.27-30	Шинжээчдийн багийг томилох, гэрээ байгуулах
	2021.10.01	Шинжээчдэд өөрийн үнэлгээний тайланг хавсралтын хамт хүлээлгэн өгөх
	2021.10.11	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгөх
	2021.10.12	Магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн сургууль дээр очин, шинжээчийн баг ажиллах бэлтгэлийг хангуулах
	2021.10.14-15	Шинжээчид сургууль дээр ажиллах
	2021.10.20	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгөх
	2021.10.21	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж, санал авах
	2021.10.22	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгөх
	2021.10.25	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэх
	Хуваарьт хуралдаан	Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж, шийдвэрлүүлэх
<b>Шалгуур шаардлага /журам/</b>	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолын гуравдугаар хавсралт “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага”-ыг баримтлан ажиллав.	

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Монгол улсын шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн, физик математикийн ШУ-ы доктор, профессор Д.Чүлтэм, физик математикийн ШУ-ы доктор, ОХУ-ын Петрийн шинжлэх ухааны академийн сурвалжлагч гишүүн, профессор Д.Халтар нарын санаачлагаар МУИС-ийн Физик математикийн факультетийн ерөнхий физикийн тэнхмийн харъяанд “Агаар мандлын оптикийн хэмжилтийн лаборатори” 1965 онд байгуулагдсанаар МУИС-д геофизикийн салбарын үндэс суурь нь тавигдсан.

- 1965-МУИС-ийн Физик математик ерөнхий физикийн тэнхим “Агаар мандлын оптикийн хэмжилтийн лаборатори”
- 1978-Геофизикийн оргил нэртэй бие даасан нэгж
- 1991- МУИС, ШУА-ийн дундын Геофизикийн судалгааны төв
- 1995- МУИС физикийн факульте, ФЭС-д Геофизикийн тэнхим
- 2014-МУИС-ийн ШУС-ийн Геологи, геофизикийн тэнхим

Геофизик” хөтөлбөрөөр физикийн III ангиас геофизикч мэргэжлээр мэргэшүүлэх сургалтыг анх 1968 онд явуулж эхэлсэн бөгөөд 1971 онд анхны төгсөлтийг хийж байсан бол 1993 оноос “Геофизик” мэргэжлийн бакалаврын сургалтыг тасралтгүй явуулж, нийт 23 удаагийн төгсөлт хийсэн байна. “Хэрэглээний геофизик” бакалавр хөтөлбөрөөр 2002-2017 онд сургалт явуулсан.

МУ-ын хувьд, D053205 индекстэй геофизик хөтөлбөрөөр бакалаврын сургалтыг явуулж байгаа 3 сургууль байна. /МУИС, ШУТИС, Улаанбаатар их сургууль/  
МУИС-ийн ШУС-ийн Геологи, геофизикийн тэнхим нь БШУ-ын сайдын холбогдох тушаал, журмын дагуу МУИС-ын захирлын 2014 оны А/259 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Геофизик”-ийн шинэчилсэн хөтөлбөрөөр геофизик, ашигт малтмалын эрэл хайгуулын геофизик, астрономи, инженер геофизик гэсэн 4 мэргэжлээр бакалаврын сургалтыг явуулж байна.

## III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

#### 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Монгол орны нийгэм, эдийн засгийн онцлог, байгалийн нөхцөл болон мэргэжлийн салбарын хөгжлийн хэтийн төлөв зэргийг харгалзан, оролцогч талуудын эрэлт, хэрэгцээ, ашиг сонирхолд нийцүүлэн, үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан “Геофизик” хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлагыг амжилттай тодорхойлсон байна.

Тухайлбал, (1) МУ-ын шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөөнд тодорхойлсон “байгалийн шинжлэх ухааны тэргүүлэх чиглэл болгон Гео-

шинжлэх ухаанд тулгуурласан онолын суурь судалгаа хийх, антропоген гаралтай орчны бохирдлыг багасгах арга хэрэгсэл, технологи бий болгох, (2) МУ-ын ҮХЦБ-д дэвшүүлсэн “уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн төлөв байдлыг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоож, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн бодлого хэрэгжүүлэх, (3) Гурван тулгуурт хөгжлийн бодлогын “МУ-ын эдийн засгийн өндөр өсөлтийг хангах уул уурхайг хөгжүүлж, томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулан иргэдэд ногдол ашиг хуваарилах нөхцөлийг бүрдүүлэх” тухай зорилт, (4) Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогын зорилт зэрэг нь Геофизик хөтөлбөрийн мэргэжлийн алсын хараа, эрэлт хэрэгцээнд тусгагдсан байна.

Улс орны нийгэм, эдийн засаг, зах зээлийн хэрэгцээ шаардлагын улмаас Геофизикийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх дараах 3 үндэслэлийг дурдсан байна.

- Суурь судалгааны чиглэлийг хөгжүүлэх- газар хөдлөл, түүнээс үүсэх гамшгийн талаар төрөөс анхаарч Монгол орны болон бүс нутгийн хэмжээний геофизикийн болон газар хөдлөлийн суурь судалгааны ажлуудыг эрчимжүүлэх
- Ашигт малтмалын шинэ ордуудыг нээж илрүүлэх судалгаануудыг эрчимжүүлэх- ашигт малтмалын эрэл хайгуулын ажилд геофизикийн дэвшилтэт арга, аргачлал, технологийг хэрэглэх
- Хэрэглээний геофизикийн судалгааг хөгжүүлэх- Хөдөө аж ахуй бэлчээр усжуулалт, газар тариалан, зам харилцаа, цахилгаан эрчим хүч, барилга хот байгуулалт, зам гүүр барих салбарт инженер геофизикийн судалгааны ажлуудыг хийх

2014 онд МУИС-ийн бүтцийн өөрчлөлт ба хөтөлбөрийн шинэчлэлтийн хүрээнд Геофизик хөтөлбөрийг шинэчлэн боловсруулахдаа өндөр хөгжилтэй орнуудын ижил салбар, мэргэжлийн бакалаврын зэрэг олгох хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа хийжээ.

Дэлхийн тэргүүлэх Стейнфорд, Техас А&М болон Оклахома их сургуулиудын Геофизикийн хөтөлбөрүүдтэй болон Монгол улсын их, дээд сургуулиудад хэрэгжиж буй ижил төстэй хөтөлбөрүүдтэй тодорхой хэмжээнд харьцуулан судалж, өөрийн хөтөлбөрийн онцлог, давуу болон дутмаг талуудыг тодорхойлж өгсөн нь сайшаалтай байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд хийсэн дүн шинжилгээ, ажлын төлөвлөгөө, бенчмарк, судалгааны танилцуулга /PEST, STEEP гэх мэт/
- Гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа, бенчмарк

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Геофизик хөтөлбөрийг 2014 онд либерал арт чиглэлийг баримтлан шинэчлэн боловсруулсан ч уламжлалт сургалтын хэв маягийг хадгалан үлдсэн.
- МУИС-ийн геофизикийн хөтөлбөр нь АНУ-ын Стейнфорд их сургуулийн хөтөлбөртэй тодорхой үзүүлэлтээрээ давхцан дүйцсэн байна.

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийг ил тод, нээлттэй байлгаж, сонирхогч талуудтай нягт хамтран ажиллах эргэх холбоо бүхий харилцааны систем тодорхой бүрдээгүй.

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийг ил тод, нээлттэй байлгаж, сонирхогч талуудтай нягт хамтран ажиллах эргэх холбоо бүхий харилцааны системийг бий болгох

## **1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

“Геофизик” хөтөлбөрийн зорилгыг бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага болон МУИС-ийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн, геофизик мэргэжлийн онцлог, оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагыг тусган өргөн хүрээнд тодорхойлсон байна.

### **Геофизик мэргэжлийн хөтөлбөрийн зорилго:**

- Геофизикийн шинжлэх ухааны онол, арга зүйн мэдлэгийг бүрэн эзэмшиж, дэлхий судлалын тодорхой асуудлаар судалгаа шинжилгээний ажил хийх ур чадварыг эзэмшсэн, төрийн болон эрдэм шинжилгээний байгууллагад мэргэжилтэн болон судлаачаар ажиллах, геологийн болон геофизикийн хайгуулын улсын ба хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид геофизикчээр ажиллах, аж ахуйн нэгжийг үүсгэн зохион байгуулах, удирдах мэдлэг чадвар эзэмшсэн мэргэжилтэн бэлтгэх

Хөтөлбөрөөр төгсөгчийн загварыг чөлөөт мэдлэг буюу либерал арт үзэл баримтлалд тулгуурлан гаргасан нь төгсөгч мэргэжлийн, нийгмийн болон хувь хүний олон талт компетенцийг эзэмшсэн мэргэжилтэн, хувь хүн болж хөгжих, төлөвших боломжийг олгож байна.

МУИС-ийн геофизикийн мэргэжлээр суралцан төгсөгчид нь дараах мэргэжлийн мэдлэг, ур чадварыг эзэмшиж, хөдөлмөрийн зах зээл дээр бэлтгэгдэн гардаг. Үүнд:

- Дэлхийн физик орнуудын үүсэл, зүй тогтол, өөрчлөлт хувьслын талаарх онолын суурь мэдлэг эзэмшсэн байх;
- Геологийн шинжлэх ухааны үндсэн мэдлэгийг эзэмшсэн байх;
- Хайгуулын геофизикийн судалгааны аргуудын онолын үндсийг ойлгож практикт хэрэглэх чадварыг эзэмшсэн байх;
- Геофизикийн мэдээлэл боловсруулалтын онолын үндэс ба арга зүйг эзэмшсэн байх;
- Физик математикийн шинжлэх ухааны мэдлэгийг эзэмшсэн байх;
- Хэмжилтийн материал, тоон өгөгдлийг мэргэжлийн программ хангамж ашиглан боловсруулалт, геологи, геофизикийн тайлан хийх ур чадвар эзэмшсэн байх

### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн төгсөгчийн загвар
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон баримт бичиг
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох, өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлсэн талаар баримт материал

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Анхаарах асуудал:**

- Төгсөгчийн загварт хийсэн SWOT шинжилгээний үр дүнд гарсан сул тал болох төгсөгчдийн гадаад хэлний ба програмчлалын мэдлэг болон хээрийн, үйлдвэрлэлийн дадлагын багц цаг дээр анхаарах

### Зөвлөмж:

- Гадаад хэл ба программчлалын хичээлүүдийн багц цагийг нэмэгдүүлэн хээрийн болон үйлдвэрлэлийн дадлагын хичээлийг илүү түлхүү оруулах
- Гадны хөрөнгө оруулалт буурах, хайгуул, судалгааны ажил багасах нь ажлын байрны нийлүүлэлтэд нөлөөлөх эрсдэлтэй учраас ажил олгогчидтой түншлэх замаар мэргэжлийн ажил эрхлэх боломжийг бий болгох

### 1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт, бичгүүд нь холбогдох хууль, журам, заавар, зөвлөмжийн дагуу хийгдсэн байна. Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн матрицыг боловсруулан суралцагчдад олгох мэдлэг, ур чадварыг хичээлийн агуулгатай уялдуулан тодорхойлсон нь шинэлэг болжээ.

#### Геофизик мэргэжлийн (D053205)-ийн сургалтын хөтөлбөрийн бүтэц

Хөтөлбөрийн бүрдэл хэсэг	Хөтөлбөрөөр суралцагчдад олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга	Багц цаг
Ерөнхий суурь	Дээд боловсролын үндэс буюу ойлгомжтой ярих, бичих, тоон болон тоон бус мэдээллийг боловсруулах, олон ургальч үзэл баримтлалын учир шалтгааныг таньж мэдэх, бусад мэргэжлийн хүмүүстэй үр дүнтэй хамтарч ажиллах, харилцан суралцах мэдлэг ур чадварууд эзэмшүүлэх зорилго бүхий заавал болон сонгон суралцах	37 цаг
Мэргэжлийн суурь	Хөтөлбөрийн суурь мэдлэг, мэргэжлийн чиглэлийн анхдагч ур чадварыг эзэмшүүлэх, мэргэжлийн ёс зүй, эрх зүйн суурь ойлголтыг өгөх зорилго бүхий заавал болон сонгон судлах	9 цаг
Мэргэжлийн	Оюутны суралцах үндсэн мэргэжлийн тодорхой мэдлэг, чадвар, дадлыг олгох, заавал болон сонгон суралцах	45 цаг заавал 15 цаг сонгох
Чөлөөт сонголт	Оюутны хавсарга болон хос мэргэжил эзэмших, магистрын хөтөлбөрийн зарим хичээлүүдийг судлах, их сургуулийн хэмжээнд хүссэн хичээлээ сонгон үзэх	15 цаг
	Нийт цаг	121 цаг

### Илрэл нотолгоо:

- МУИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хорооны 2014 оны А/259 тушаал
- Геофизик хөтөлбөрийн суралцахуйн үр дүн ба хичээлүүдийн матриц
- Батлагдсан хичээлийн хөтөлбөр
- Хурлын тэмдэглэл

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

### Анхаарах асуудал:

- Хөтөлбөр төлөвлөлтийн баримт бичгүүдэд холбогдох дээд шатны байгууллагуудын шийдвэр, хууль, тогтоомж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган цаг тухайд нь өөрчлөн сайжруулж, сургалтанд хэрэгжүүлж байх талаар анхаарах



### **Зөвлөмж:**

- Хөтөлбөр төлөвлөлтийн баримт бичгүүдэд гарсан холбогдох санал зөвлөмжүүдийг тусгаж цаг тухайд нь сайжруулж байх

### **1-р шалгуурын үнэлгээ**

№	Шалгуур	Шинжээчийн үнэлгээ
1.1	Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага	Бүрэн хангасан
1.2	Хөтөлбөрийн зорилго	Бүрэн хангасан
1.3	Хөтөлбөрийн баримт бичиг	Бүрэн хангасан

**1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:** Хөтөлбөрийн танилцуулга холбогдох бичиг баримтуудтай танилцахад геофизик хөтөлбөрийн зорилго зорилтыг мэргэжлийн дээд боловсролын нийтлэг эрмэлзлэл МУИС-ийн эрхэм зорилго, сургалтын бодлогод нийцүүлэн дотоодын болон дэлхийн томоохон дээд сургуулиудын ижил төстэй хөтөлбөрийн агуулгатай харьцуулах замаар шинэчлэн боловсруулсан байна гэж дүгнэн “**Бүрэн хангасан**” гэсэн үнэлгээг өгч байна

### **Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа**

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

#### **2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Геофизик хөтөлбөр нь агуулгын ба сургалтын төлөвлөгөөний шинэчлэлийг дээд боловсролд баримтлах боловсролын яамны бодлого чиглэлийн хүрээнд болон МУИС-ийн байгалийн ухааны чиглэлийн бодлого, тухайн хөтөлбөрөөр суралцагчийн эзэмших чадвар ба хүрэх үр дүнд үндэслэн ерөнхий эрдэм ба мэргэжлийн, мэргэшүүлэх хичээлийн агуулга ба харьцааг зохистойгоор хангаж шинэчлэлийг тогтмол хийж ирсэн байна.

Геофизик хөтөлбөрөөр сургалт явуулж эхэлснээс хойш 11 удаа тус хөтөлбөрт агуулга ба бүтцийн сайжруулалт шинэчлэл хийсэн байна.

№	Мэргэжил	Индекс	Төлөвлөгөө батлуулсан он
1	Дэлхий судлал, геофизик		1993
2	Геофизик	Д443204	1998
3	Геофизик	Д443204	1999
4	Геофизик	Д443204	2001
5	Геофизик	Д440104	2002
6	Геофизик	D441200	2005
7	Геофизик	D441200	2007
8	Геофизик	D441200	2009
9	Геофизик	D441201	2010
10	Геофизик	D441201	2013
11	Геофизик	D053205	2014

2001-2009 онуудад хөтөлбөрт хийгдсэн шинэчлэл өөрчлөлтүүд нь агуулгын хувьд эрс өөрчлөлт бага хийгдсэн, харин хичээлүүдийн уялдаа холбоо, багц хичээлийн хуваарилалт, цагийн харьцаа зэрэг өөрчлөлтүүдийг хийж шинэчилж байсан байна.

2010 оны хөтөлбөрийн шинэчлэл нь хичээлүүдийн давхардлыг арилгах, бакалаврын түвшинд багц цагийн доод хязгаарыг тогтоох, бутархай кредитийг бүхэл болгох, бага кредит бүхий хичээлүүдийг нэгтгэх зэрэг өөрчлөлтүүд тусгасан бол 2013 оны хөтөлбөрийн шинэчлэлтээр бүрэлдэхүүн сургуулийн мэргэжлийн суурь хичээлийн багцыг бий болгосон байна.

МУИС нь 2014 онд либерал боловсролын системд шилжсэнтэй холбоотойгоор Геофизикийн хөтөлбөрийн агуулгад ихээхэн өөрчлөлт орсон, тухайлбал хэрэглээний геофизик хөтөлбөрөөр бие даасан сургалт явуулахгүй болж, геофизик ба хэрэглээний геофизикийн хөтөлбөрүүдийг нэгтгэсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулсан.

#### Илрэл нотолгоо:

- МУИС-ийн Захирлын 2010 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 2/557 тоот тушаал
- Хичээлийн индекс, хичээлийн суралцахуйн үр дүнгийн матриц
- Удирдлагын мэдээллийн систем дэх сонголтууд
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд хийсэн шинжилгээ
- Дадлагын талаар хамтран ажиллах гэрээ, санамж бичиг, удирдамж, журам, ажлын тайлан, анализ
- Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан график /хөтөлбөрийн мод/
- Суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгаа

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

**Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрт шинэчлэл хийж, сургалтын арга зүйг тухайн хичээлийн онцлогт тохируулан боловсруулж хичээлийн хөтөлбөрт түлхүү тусгахад анхаарах

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн сургалтын агуулга, шинэчлэлийг тогтмол хийх

## **2.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

МУИС-ийн сургалтын журамд лекц, семинар, лаборатори болон дадлагын тодорхойлолтыг зааж, тухайн хичээлийн сургалтын арга зүйн ерөнхий хэлбэрийг тусгасан байна. Сургалтад ашиглаж буй арга зүй нь суралцагчийн шүүмжлэлт сэтгэхүйг хөгжүүлэх, мэдлэг хуримтлуулах, бүтээлч санаачлага бий болгох, өөрийн үзэл бодлыг үндэслэлтэй илэрхийлэх, онолын мэдлэгийг бодит амьдрал ба үйл ажиллагаанд хэрэглэх ур чадварыг эзэмшүүлэхэд чиглэгддэг.

Харин тухайн хөтөлбөрийн хичээлийг удирдан явуулж буй багш нар нь суралцагчийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн сургалтын шинэлэг аргыг нэвтрүүлэхийг зорьж ажилладаг бөгөөд сургалтад мэдээлэл харилцаа холбоо, технологийн дэвшилтэт программ хангамж, техник хэрэгслийг ашиглаж байна.

**Илрэл нотолгоо:**

- Сургалтын аргазүйг хэрэгжүүлэх загвар, заавар, зөвлөмж
- Сургалтын аргазүйд хийсэн анализ судалгааны баримт материал

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

**Анхаарах асуудал:**

- Сургалтын арга зүйг улам сайжруулан тухайн хичээлийн онцлогт тохируулан боловсруулж байхад анхаарах

**Зөвлөмж:**

- Цаашид оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн лекц, семинар, лаборатори болон дадлагын хичээлүүдийн тодорхойлолтыг зааж өгөхдөө тухайн хичээлийн арга зүйн ерөнхий хэлбэрийг тусган, МУИС-ийн хичээлийн хөтөлбөр боловсруулах зааврын дагуу шинэчлэлтийг хийж сургалтын арга зүйг тухайн хичээлийн онцлогт тохируулан боловсруулж хичээлийн хөтөлбөрт тусгаж байх.

## **2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Сургалтын журамд тухайн хичээлээр суралцагчийн улирлын туршид эзэмшсэн мэдлэг, чадварын үнэлгээг гаргах хувьчилсан оноо, үсгэн болон тоон үнэлгээний харьцаа, аргачлалыг тодорхой заасан. Мөн тухайн хичээл бүрийн хөтөлбөрт суралцагчийн үнэлэх үнэлгээг оруулж өгдөг байна.

Зарим нэг мэргэжлийн гүнзгийрэн судлах чиглэлийн хичээлд үнэлгээний арга зүй тодорхойгүй байгаа нь суралцагчийн бодит чадварыг үнэлэхэд учир дутагдалтай байгаад анхаарах шаардлагатай байна.

### Илрэл нотолгоо:

- Сургалтад ашиглаж буй үнэлгээний аргазүйн судалгаа (Блум таксономи, Рубрик арга)
- Хичээл нэг бүрийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээ, анализ (шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сорилын санд хийсэн шинжилгээ)
- Явцын болон төгсөлтийн шалгалтын журам
- Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулалт, дүгнэлт (голч дүн, хичээлд унасан оюутны тоо, амжилт, чанар г.м)

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын журамд тухайн хичээлээр суралцагчийн улирлын туршид эзэмшсэн мэдлэг, чадварын үнэлгээг гаргах хувьчилсан оноо, үсгэн болон тоон үнэлгээний харьцаа, аргачлалыг тодорхой заасан байна.

### Анхаарах асуудал:

- Суралцагчийн мэдлэг чадварыг үнэлэх нэгдсэн арга зүйг нэвтрүүлж, зарим нэг мэргэжлийг гүнзгийрүүлэн судлах хичээлийн үнэлгээний арга зүй тодорхой биш байгаад анхаарах

### Зөвлөмж:

- Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээний механизмыг улам боловсронгуй болгох

### 2-р шалгуурын үнэлгээ:

№	Шалгуур	Шинжээчийн үнэлгээ
2.1	Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл	Бүрэн хангасан
2.2	Сургалтын арга зүй	Бүрэн хангасан
2.3	Суралцагчийн үнэлгээ	Бүрэн хангасан

**2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:** Сургалтын агуулга нь цогц чадамжийг олгоход чиглэсэн онол практикийн зохистой харилцаатай суралцагч төвтэй мэдээлэл харилцаа холбооны дэвшилтэд технологи ашиглаж байгаа тул **“Бүрэн хангасан”** гэсэн үнэлгээг өгөв.

### Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

#### 3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Хичээлийн байр, сургалтын анги танхим, лаборатори, урлан, бие даан болон багаар ажиллах орчны хүрэлцээ, хангамж, ашиглалтын талаар суралцагчид болон төгсөгчдөөс авсан сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээс харахад жилээс жилд сургалтын орчин сайжирч, анги танхим, лабораторийн талбайн хэмжээ оюутанд хүрэлцээтэй болсон байна.

#### Сургалтын орчин

### **Сургалт, судалгааны лабораториуд**

- Хэрэглээний геофизикийн лаборатори
- Петрофизикийн лаборатори
- Геологийн суурь судалгааны лаборатори
- Палентологийн лаборатори
- Агаар мандлын оптикийн хэмжилтийн лаборатори
- Астрономийн кабинет
- Инженер геологи, геотехникийн лаборатори
- Шатах ашигт малтмалын лаборатори
- Геомэдээлэл боловсруулалтын лаборатори

### **Лиценз бүхий програм хангамж**

#### **Илрэл нотолгоо:**

- Хичээлийн байр, сургалтын анги танхим, лаборатори, урлан, бие даан болон багаар ажиллах орчны хүрэлцээ, хангамж, ашиглалтын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, хийсэн ажлын тайлан
- Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмж, сэтгэл ханамжийн судалгаа

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хичээлийн байр, сургалтын анги танхим, лаборатори, урлан, бие даан болон багаар ажиллах орчны хүрэлцээ, хангамж, ашиглалтын талаар суралцагчид болон төгсөгчдөөс авсан сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээс харахад жилээс жилд сургалтын орчин сайжирч, анги тэнхим, лабораторийн талбайн хэмжээ оюутанд хүрэлцээтэй болсоор иржээ.

#### **Анхаарах асуудал:**

- Зарим багаж тоног төхөөрөмжийг шинэчлэхэд анхаарч ажиллах

#### **Зөвлөмж:**

- Улсын болон хувийн хөрөнгө оруулалттай мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллах талаар санаачлага гаргах

### **3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

МУИС нь “сургах ба суралцах үйл явцыг дэлхийн тэргүүлэх түвшинд хүргэх” стратегийн төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлийнхээ хүрээнд сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмжийг сайжруулах, судалгааны лабораторийг өргөжүүлэх, программ хангамжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, технологийн дэвшилтэт арга зүйг ашиглах зэрэг цахим

### **Сурах бичиг, мэдээллийн сан**

- МУИС-ийн номын сан
- Хөтөлбөрийн номын сан
- Виртуал мэдээллийн сангууд
- Дижитал видео, аудио болон цахим ном, сурах бичгүүд

#### **Хичээл, практикийн материаллаг нөөц**

- Дээж
- Хэвлэмэл үзүүлэн
- Тараах материал
- Бусад хэрэглэгдэхүүн

сургалтын болон судалгааны лаборатори ажиллуулах журмуудыг гарган, хэрэгжүүлж байна.

Геологи, геофизикийн тэнхим нь судалгааны болон сургалтын дараах лабораториудтай.

#### **Судалгааны лаборатори**

- Геологийн суурь судалгааны лаборатори
- Агаар мандлын оптикийн хэмжилтийн лаборатори
- Инженер геологи, геотехникийн лаборатори

#### **Судалгааны лаборатори**

- Шатах ашигт малтмалын лаборатори
- Петрофизикийн лаборатори
- Палентологийн лаборатори
- Хэрэглээний геофизикийн лаборатори
- Астрономийн кабинет
- Минералогийн лаборатори
- Петрографийн лаборатори

Геофизикч мэргэжлийн суралцагчдад сургалтын хэрэглэгдэхүүн, нөөц, хүртээмж нь хангалттай бөгөөд сургалтын болон судалгааны лабораториуд нь шаардлагатай багаж, төхөөрөмжүүдээр хангагдсан байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Суралцагчдаас авсан сэтгэл ханамжийн судалгааны дүн
- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгаа
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж
- Е-контент түвшинд боловсруулсан сургалтын материал

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Геофизикч мэргэжлийг эзэмшихээр суралцаж буй суралцагчдад шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, нөөц, хүртээмж нь хангалттай. Сургалтын болон судалгааны лабораториуд нь шаардлагатай багаж, төхөөрөмжүүдээр хангагдсан байна. Суралцагчдаас авсан сэтгэл ханамжийн судалгааны дүн нь сургалтын хэрэглэгдэхүүн, сэтгэл ханамжтай байгааг харуулжээ. Лабораторийн ажлын заавар, лабораторид ажиллах аюулгүй байдлын зөвлөмж, багажтай ажиллах заавар, хээрийн дадлагын удирдамж зэрэг сургалтын ажлыг зохион байгуулахад шаардлагатай заавар, зөвлөмж, удирдамжаар суралцагчдыг хангажээ. Е-контентийн түвшинд бэлтгэж боловсруулсан сургалтын материалыг сүүлийн жилүүдэд тодорхой түвшинд хийж эхэлсэн байна.

#### **Анхаарах асуудал:**

- Сургалт, судалгааны лабораторийн зарим багаж төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах
- Е-контентийн түвшинд бэлтгэсэн сургалтын материалыг баяжуулж сайжруулах тал дээр анхаарах

- Суралцагчдын орчин үеийн багаж хэрэгсэлтэй ажиллах чадварыг улам сайжруулах талаар төлөвлөгөөтэй ажиллах дутмагаас хөдөлмөрийн зах зээл дээрх өрсөлдөх чадвар сул байгааг анхаарах

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн онцлогоос хамаарах зайлшгүй шаардлагатай сургалт судалгааны програм хангамж хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байх
- Суралцагчдын орчин үеийн багаж хэрэгсэлтэй ажиллах чадварыг сайжруулах тал дээр төлөвлөгөөтэй ажиллах

### **3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

МУИС-ийн ном сан нь 2020-2021 оны хичээлийн жилд 390,000 гаруй хэвлэмэл болон цахим бүтээлийн сан хөмрөгтэй бөгөөд олон улсын номын сангийн автоматжуулсан КОНА цогц программ хангамж өгөгдлийн бааз бүхий онлайн мэдээллийн сангуудаар оюутан суралцагчдад үйлчилж байна.

3000 орчим геофизик хөтөлбөрийн үндсэн сурах бичиг болон лабораторийн ажлын гарын авлагууд байдгаас 45% нь монгол хэл дээр бичигдсэн мэргэжлийн ном, сурах бичиг байна. Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэр хангалттай байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт, сэтгэл ханамжийн судалгаа
- Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгаа
- Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгаа

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Олон улсын стандартад нийцсэн номын сантай.
- Тухайн хөтөлбөрийн англи хэл дээрх сурах бичгүүдийг amazon.com-оос худалдан авах боломжийг сургуулийн зүгээс олгодог.

#### **Анхаарах асуудал:**

- Монгол хэл дээр бичигдсэн үндсэн сурах бичгийн тоо хэмжээг нэмэгдүүлэх
- Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгааг суралцагчдаас авах

#### **Зөвлөмж:**

- Суралцагчдын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх, хичээлийг цахим болон танхимын байдлаар хослуулан явуулах
- Хос мэргэжлийг сонгох боломжийг бүрдүүлэх талаар санаачлагатай ажиллах

#### **3-р шалгуурын үнэлгээ:**

№	Шалгуур	Шинжээчийн үнэлгээ
3.1	Сургалтын орчин	Бүрэн хангасан
3.2	Сургалтын хэрэглэгдэхүүн	Бүрэн хангасан
3.3	Сурах бичиг, мэдээллийн эх үүсвэр	Бүрэн хангасан

**3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:** МУИС нь сургуулийн орчинг сайжруулах чиглэлээр идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаагийн үр дүнд багш оюутнууд дээд боловсролын байгууллагын стандартад нийцсэн сургалтын орчинд суралцаж байгаа тул энэ шалгуурыг “**Бүрэн хангаж байна**” гэж үзэх үндэслэлтэй юм.

## Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

### 4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

МУИС нь “Хөтөлбөрийн хорооны журам”-ыг 2016 оны 12-р сарын 23-ны өдрийн А/347 тоот тушаалаар батлан гаргаж, энэхүү журмаар хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагаагаа явуулж байна.

МУИС-ийн бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор Геологи, Минералогийн тэнхим болон Геофизикийн тэнхимүүд нэгдэж, 2014 оны 2-р сард Геологи, геофизикийн тэнхим байгуулагдсан.



Тэнхимийн хөтөлбөрийн дэд хороогоор сургалтын хөтөлбөртэй холбоотой асуудал, өөрчлөлтийг бүх багш нарын оролцоотойгоор саналыг тусган хэлэлцүүлдэг. Сургалтын удирдлага мэдээллийн SiSi системийг сургалт, удирдлага, зохион байгуулалттай холбоотой үйл ажиллагааг хөнгөвчлөх, чанаржуулах, шуурхай, найдвартай, ил тод, хяналттай болгох зорилгоор ажиллуулдаг.

### Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хороо, тэнхимийн хурлын шийдвэр, тэмдэглэл
- Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай дүрэм журмуудыг нийтэд нээлтэй МУИС-ийн вэбсайтад байршуулсан.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгчийн нэгжийн урт, дунд, богино хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан
- Сургалтын удирдлага, мэдээллийн SiSi системийн ашиглалт, хяналт, ил тод байна.

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

**Онцлог зүйл/Туршлага:**



- Хөтөлбөрийн хорооны бүтэц оновчтой, талуудын оролцоог бүрэн хангасан
- Хөтөлбөрийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн баримт бичгүүдийг шаардлагатай үед шинэчлэн сайжруулж нийтэд нээлттэй ил тод вэбсайтад байршуулсан
- Харилцагч талуудаас ирсэн санал гомдол, зөвлөмжийг мэдээллийн программын тусламжтайгаар харьяа албадууд нь шийдвэрлэн хариуг өгөх системтэй ажиллагаа хэрэгжүүлж байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх урт, богино, дунд богино хугацааны төлөвлөгөөг хэрэгжүүлдэг.

#### **Анхаарах асуудал:**

- Суралцагчдаас сургалтын албанд ирсэн санал гомдлын талаар гаргасан шийдвэр, хэрэгжүүлсэн байдлын талаарх судалгааг тогтмол хийж байх

#### **Зөвлөмж:**

- Тэнхимийн хөтөлбөрийн хорооны хуралдаанд хэлэлцэх асуудлаас хамааруулан зарим тохиолдолд боломжтой гэж үзвэл төгсөгчийн төлөөллөөс урин оролцуулж байх
- Мэдээллийн системд сайжруулалтыг цаг тухайд нь хийж байх

#### **4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Геофизик хөтөлбөрийн удирдлагын нэгжүүд болох тэнхим, бүрэлдэхүүн сургууль, Захиргааны нэгжийн хүрээнд дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг.

Геологи, Геофизик тэнхим нь БНСУ, Япон, ОХУ, БНХАУ зэрэг улс орнуудын сургалт, судалгаа, шинжлэх ухааны байгууллагуудтай байнгын хамтын ажиллагаатай бол Геологийн төв лаборатори ТӨҮГ, Монголросцветмет ТӨҮГ, Палентологи геологийн хүрээлэн, Геологийн судалгааны төв, Эрдэнэт үйлдвэр, Монполимет ХХК, ШУА-ийн Геологийн хүрээлэн болон Монголын Геологийн холбоо зэрэг сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллаж, олон улсын ба дотоодын төрөл бүрийн байгууллагуудтай төсөл хэрэгжүүлж, гэрээ хэлцэл хийн амжилттай үр дүнд хүрсэн байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн гэрээ, хэлцэл, ажлын тайлан, олон улсын ба бусад эрдэм шинжилгээний хурал, семинарт оролцсон тухай баримтууд
- Багш, суралцагч солилцоо, гадаад дотоодын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан талаарх судалгаа, нотолгооны баримт материалууд
- Хамтын ажиллагааны хүрээнд хийгдэж буй хамтран ажиллах санамж бичиг ба гэрээ хэлэлцээр зэргийн талаарх тойм
- Тэнхимийн багш нарын зүгээс мэргэжлийн холбоод, үйлдвэр үйлчилгээний байгууллага, ажил олгогч эздийн холбоо болон бусад төрийн бус байгууллагуудтай

хамтран сургалт, хурал семинар, олимпиад, хээрийн далага зэргийг зохион байгуулсан талаарх баримт, материалууд

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

**Онцлог зүйл/Туршлага:**

- Сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллаж олон улсын ба дотоодын төрөл бүрийн байгууллагуудтай төсөл хэрэгжүүлж, гэрээ хэлцэл хийн амжилттай үр дүнд хүрсэн
- Гадаадын их, дээд сургуулиудад ахисан түвшний сургалтанд тэтгэлгээр суралцах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.
- Суралцагч, төгсөгч, ажил олгогчдын уулзалтыг тогтмол жил бүр зохион байгуулдаг.
- МГФХ болон бусад байгууллагууд сургалт, судалгааны ажлыг дэмжиж ажилладаг

**Анхаарах асуудал:**

- Тэнхимийн хөтөлбөрийн хороо болон тэнхимийн бүрэлдэхүүн нь оюутан суралцагчдад гадаад дотоодын байгууллага, сангийн нэрэмжит тэтгэлэг олгох боломжийг эрэлхийлж идэвхи, санаачлагатай байхад анхаарах

**Зөвлөмж:**

- Геофизик мэргэжлийн төгсөгчдийн холбоог байгуулах талаар санаачлагатай ажиллах

### 4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

МУИС нь өөрийгөө санхүүжүүлэх замаар үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлаа нөхөн ажилладаг төрийн өмчийн сургууль юм.

Геологи, Геофизик тэнхим нь Шинжлэх Ухааны сургуульд харьяалагддаг бөгөөд нь ШУС-ийн захирал нь санхүүжилтийг захиран зарцуулах эрхтэй.

Геофизик хөтөлбөрийг хэрэгжүүлж буй Геологи, геофизикийн тэнхим нь халаалт, цахилгаан, цэвэр бохир ус ашиглалтын төлбөрөөс бусад бүх зардлаа өөрийн үйл ажиллагааны зардлаас санхүүжүүлдэг байна.

МУИС-ийн судалгааны ажлын санхүүжилтийн журмынхаа дагуу Геологи, Геофизикийн тэнхимийн багш нар судалгааны төслүүдийн дэмжлэг аван хэрэгжүүлдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн тухайн жилийн санхүүгийн мэдээлэл
- Хичээлийн жилийн орлого, зарлагын судалгаа

### ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

Геологи, Геофизикийн тэнхимийн санхүүгийн орлого, зарлагын мэдээлэл

ГГФТ	Хичээлийн жил				
	2016-2017	2017-2018	2018-2019	2019-2020	2020-2021
Оюутны тоо	134	136	135	150	
Нийт орлого /сая.төг/	452.1	625.8	345.8	361.2	
Нийт зарлага /сая.төг/	495.9	625.0	428.3	390.6	

Сургалтын лабораторийн багаж, тоног төхөөрөмжийн зардал



Тэнхимийн багш, ажилтныг дэмжих зардал, хичээлийн жилээр



Сургалтын хэрэглээдэхүүний хөрөнөг оруулалтын зардал



- Тэнхмийн багш, ажилтныг дэмжих зардлын тооцоо
- Сургалтын төлбөрийн тооцооны судалгаа
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнг нэмэгдүүлэх сургалтын орчинг сайжруулах зорилгоор шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалтын судалгаа
- МУИС-ийн дотод санхүүжилтээр хэрэгжүүлсэн төслүүд, хувийн хэвшлийн дэмжлэг, тэтгэлэг зэргээс хийгдсэн санхүүжилт, түүний зарцуулалтын талаарх мэдээлэл

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

**Онцлог зүйл/Туршлага:**

- “Асуудал, шийдэл-2018” форумын хүрээнд байгуулсан гурван талт гэрээнд заасан оюутны сургалтын төлбөр нэмэгдүүлэхгүй байх үүргийг хэрэгжүүлж байна.

**Анхаарах асуудал:**

- Төсөл, хөтөлбөрийн оролцоог нэмэгдүүлэх

**Зөвлөмж:**

- Санхүүжилтийн талаар гадаад дотоодын эх үүсвэрүүдийг байнга эрэлхийлж байх

#### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

МУИС нь 2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн мэргэжлийн хөтөлбөрт бус бүрэлдэхүүн сургуульд элсэлт авч, ерөнхий суурь хичээл судалсны дараа оюутнуудад мэргэжлийн хөтөлбөрийг сонгох боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Геологи, геофизик хөтөлбөрийг сурталчлах өдөрлөгийг жилдээ 2 удаа явуулж, оюутны эрдэм, шинжилгээний хурлыг тогтмол явуулж оюутан, олон нийтэд танилцуулан сурталчилдаг байна. Хөтөлбөрийг сурталчлах өдөрлөг, эрдэм шинжилгээний хурал, олимпиад, уралдаант танин мэдэхүйн тэмцээн гэх мэт идэвхжүүлэлтийн үйл ажиллагаа явуулдаг хэдий ч өөрийн үнэлгээний тайлангийн “Геофизик хөтөлбөрт оюутан элсүүлэх ба элсэгчдийн тоо” гэсэн хүснэгт 4.15 дэхь элсэгчдийн тоо нэмэгдэхгүй байгаа нь хөтөлбөрийг маркетингийн идэвхжүүлэлт оновчтой бус, геофизик мэргэжлийн талаарх олон нийтийн ойлголт сул байгааг харуулж байна.

**Илрэл нотолгоо:**

- Жилдээ 2 удаа хөтөлбөрийн сурталчилгаа, оюутны эрдэм шинжилгээний хурал тогтмол явуулж байгаа тухай нотолгоо материалууд

**Шалгуурыг хангасан байдал:** Хэсэгчлэн хангасан

**Онцлог зүйл/Туршлага:**

- Видео нэвтрүүлгийг олон нийтийн мэдээллийн сувгаар хүргэж байна.

**Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийг сонгон суралцах оюутны тоог нэмэгдүүлэх зорилтот зах зээлд чиглэсэн маркетингийн хөтөлбөр хэрэгжүүлэх, маркетингийн шинэлэг идэвхжүүлэлтийг хөгжүүлэх тал дээр анхаарах
- Геофизик мэргэжлийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх контент хийж, сурталчилахад анхаарах

**Зөвлөмж:**

- Хөтөлбөр сурталчилгааг хичээлийн жилийн туршид байнга, оновчтой хийж байх

**4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Тэнхим бүр тухайн хөтөлбөртэй холбоотой мэдээллийг олон нийтэд ил, тод нээлттэйгээр албан ёсны цахим хуудсуудаар дамжуулан түгээдэг.

Тухайлбал, <https://www.facebook.com/геологи> тэнхимийн бакалавр, <https://www.facebook.com/геофизикийн> тэнхим, [https://www.facebook.com/Mongolian Geophysical Society](https://www.facebook.com/MongolianGeophysicalSociety)

**Илрэл нотолгоо:**

- Цахим хуудсууд

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

**Онцлог зүйл/Туршлага:**

- Мэдээллийн технологийн газар нь СиСи сургалт, удирдлагын мэдээллийн системийг бүх төрлийн үйл ажиллагаанд ашигладаг.

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн ил тод, нээлттэй, олон нийтэд хүртээмжтэй байдлыг хангахад мэдээлэл, технологийн ололтыг байнга ашиглах
- Хөтөлбөрийн онцлог, үргэлжлүүлэн суралцах боломж, гадаад дотоод хамтын ажиллагааны үр дүнг олон нийтэд сурталчилах

**4-р шалгуурын үнэлгээ:**

№	Шалгуур	Шинжээчийн үнэлгээ
4.1	Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа	Бүрэн хангасан
4.2	Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ	Бүрэн хангасан
4.3	Санхүүжилт	Бүрэн хангасан
4.4	Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт	Хэсэгчлэн хангасан
4.5	Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал	Бүрэн хангасан

**4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:** 1 шаардлагыг хэсэгчлэн хангаж байгаа ч Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт шалгуурыг “Бүрэн хангасан” гэж үзэх үндэслэлтэй.

**Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа**

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

### 5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

МУИС нь холбогдох хууль, эрх зүйн хүрээнд бакалаврын өдрийн хөтөлбөрт оюутан элсүүлэх журмыг боловсруулан баталж, энэхүү журмаараа элсэлтийг зохион байгуулдаг.

